



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 60

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.3 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванзургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Боловсрол шинжлэх ухааны газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 11,731,981,95 /арван нэгэн сая долоон зуун гучин нэгэн мянга есөн зуун наян нэгэн төгрөг ерэн таван мөнгө/ төгрөгийн балансын үнэтэй, 471,475,05 /дөрвөн зуун далан нэгэн мянга дөрвөн зуун далан тав/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 17 нэр төрлийн 47 ширхэг хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол шинжлэх ухааны газрын дарга (Ч.Уранбямба)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Актлах хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор акталж, акталснаас гарсан материалыг эргэлтийн хөрөнгөд бүртгэх;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;


2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2023 оны 12 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн
60 дугаар тогтоолын хавсралт



Боловсрол шинжлэх ухааны газрын актлах хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он, сар, өдөр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Данснаас хасах болсон шалтгаан	Актлах төрөл
1	Компьютер athena	2003-01-01	ш	1	650,168	650,168	650,168	0	Ажиллахгүй	Устгах
2	BAZ компьютер	2011-09-17	ш	2	1,178,000	2,356,000	2,356,000	0	Ажиллахгүй	Устгах
3	Могол компьютер	2011-09-17	ш	1	588,500	588,500	588,500	0	Ажиллахгүй	Устгах
4	Принтер / 1010 /	2002-01-01	ш	1	692,033	692,033	692,033	0	Ажиллахгүй	Устгах
5	асег нотебоок	1/2/2012	ш	1	890,000	890,000	890,000	0	Ажиллахгүй	Устгах
6	Хяналтын камер	1/2/2021	ш	1	1,885,900	1,885,900	1,885,900	0	Ажиллахгүй	Устгах
7	Хяналтын камер	3/14/2014	ш	1	1,496,000	1,496,000	1,496,000	471,475.05	Ажиллахгүй засвар авахгүй болсон	Устгах
8	Сандал эргэдэг	2011-12-21	ш	4	66,000	264,000	264,000	0	Ажиллахгүй	Устгах
9	Эргэдэг сандал	1997-01-01	ш	1	197,181	197,181	197,181	0	Ажиллахгүй	Устгах
10	98Н22В сандал	2002-01-01	ш	26	24,700	642,200	642,200	0	Ажиллахгүй	Устгах
11	Архивын программ	2012-06-15	ш	1	200,000	200,000	200,000	0	Шинэчлэгдсэн ашиглахгүй байгаа	Устгах

12	Plastic тайлангийн нэгтгэл	2006-12-01	ш	1	350,000	350,000	350,000	0	Шинэчлэгдсэн ашиглахгүй байгаа	Устгах
13	Acolous тайлангийн нэгтгэл	2004-01-01	ш	1	240,000	240,000	240,000	0	Шинэчлэгдсэн ашиглахгүй байгаа	Устгах
14	Жолоочийн тооцооны программ	2010-12-17	ш	1	400,000	400,000	400,000	0	Шинэчлэгдсэн ашиглахгүй байгаа	Устгах
15	Цалингийн программ	2015-08-27	ш	1	110,000	110,000	110,000	0	Шинэчлэгдсэн ашиглахгүй байгаа	Устгах
16	Санхүүгийн программ	2009-05-25	ш	1	385,000	385,000	385,000	0	Шинэчлэгдсэн ашиглахгүй байгаа	Устгах
17	Сургалтын программ	2009-05-26	ш	2	879,890.00	385,000	385,000	0	Шинэчлэгдсэн ашиглахгүй байгаа	Устгах
Нийт дүн					10,233,371.95 / арван сая хоёр зуун гучин гурван мянга гурван зуун далан нэгэн төгрөг ерэн таван мөнгө/ төгрөг	11,731,981.95 / арван нэгэн сая долоон зуун гучин нэгэн мянга есөн зуун наян нэгэн төгрөг ерэн таван мөнгө/ төгрөг	11,731,981.95 / арван нэгэн сая долоон зуун гучин нэгэн мянга есөн зуун наян нэгэн төгрөг ерэн таван мөнгө/ төгрөг	471,475.05 / дөрвөн зуун далан нэгэн мянга дөрвөн зуун далан таван/ төгрөг		